

## SikaGrout® -212 HP

**Эхний бат бэхийг маш богино хугацаанд авах, өндөр үзүүлэлттэй, агшдаггүй цементэн зуурмаг**

### Бүтээгдэхүүний тодорхойлолт

SikaGrout® -212 HP нь агшилтад тэсвэртэй, төмөрлөг агуулаагүй, эхний бат бэхийг маш богино хугацаанд авдаг, хэрэглэхэд бэлэн тулгуур гроут юм. Сонгомол түүхий эд бүхий бэлэн хольц нь нягтрал сайтай нэгэн жигд зуурмаг болно.

### Хэрэглээ:

SikaGrout® -212 HP бетон болон зуурмаг дахь агшилтанд тэсвэртэй байж, суурин дахь доргилтын нөлөөг шингээн бууруулдаг. Эхэн үеийн бат бэхэд маш богино хугацаанд хүрсэнээр машин тоног төхөөрөмжийн суурь, бүтээцийн багана, урьдчилан хүчитгэсэн тулгуурууд, гүүрний тулаасууд, төмөр замын тулгуурууд, суурний боолтууд зэрэг богино хугацаанд ачааллах шаардлагатай эдлэлүүдэд тохиромжтой.

### Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Урсах чадвар маш сайн
- Эзлэхүүний тогтвортой байдал сайтай
- Найрлагандаа хлорид агуулаагүй учир металтай хүрэлцэхдээ зэврэлт, ялгаралт зэрэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
- Эхэн үеийн шахалтын бат бэхийг маш богино хугацаанд авдаг учир богино хугацаанд ачаалалаа авч, өртөг зардалыг бууруулах боломжтой.
- Эхэн үеийн бат бэхийг богино хугацаанд авсанаар урсгал засварын холбоотой сул зогсолт, түүнтэй холбоотой өртөг зардал буурах боломжтой.
- Хоргүй, зэвэрдэггүй
- Хэрэглэхэд хялбар, бэлэн зуурмаг
- Хэмнэлттэй

## Хэлбэр төлөв

Төлөв	Нунтаг
Өнгө	Саарал
Сав баглаа боодол	25 кг цаасан ууттай

## Хадгалалт

Хадгалах нөхцөл	Сав баглаа боодлыг онгойлгож, гэмтээлгүйгээр, хуурай орчинд нарны шууд тусгалаас хамгаалах хэрэгтэй
Хадгалах хугацаа	6 сар

## Техникийн мэдээлэл

Хамрах хэмжээ	1 литр зуурмагт ойролцоогоор 2 кг нунтаг бүтээгдэхүүн орно
Нягтын хэмжээ	~ 1,5 кг/л
Зарцуулалт	1 м <sup>3</sup> зуурмагт ойролцоогоор 77 х 25кг нунтаг бүтээгдэхүүн болон 260 кг ус орно

## Хэрэглэх заавар

Гадаргууг бэлдэх	<p>Бетоны гадаргуу бат бэх байж, хуурай, тос тосоол, бетон арчилгааны бодисууд, будаг түрхлэгүүд болон бусад бохирдол болон сул хэсгүүдээс бүрэн ангид байх хэрэгтэй.</p> <p>Метал гадаргуу (төмөр, ган) нь тос тосоол, зэврэлт, шохойжилт зэргээс ангид цэвэр байх шаардлагатай.</p> <p>Шингээгч гадаргууд зуурмагыг цутгахаас өмнө сайтар чийглэх хэрэгтэй. Гэхдээ илүүдэл тогтсон ус гадаргуу дээр үлдэх ёсгүй.</p>
Холих	<p>Нунтаг бүтээгдэхүүнийг тооцоолон бэлтгэсэн ус руу хийж, хольно.</p> <p>+30°C орчинд 25кг нунтаг бүтээгдэхүүнийг ойролцоогоор 3,375 – 3,50 литр усан дээр нэмж хийж, урсамтгай, өөрөө тэгширдэг зуурмаг бэлдэнэ.</p> <p>Холигч хошуутай, бага хурдтай (хамгийн ихдээ 500 rpm) цахилгаан холигчоор нэгэн жигд зуурмаг болтол хольж өгөх хэрэгтэй.</p>
Хэрэглээ	<p>Бэлэн болсон зуурмаганд үүссэн байж болзошгүй агаарын бөмбөлгийг арилтал хүлээж байгаад цутгалтаа хийнэ. Суурийн хавтанд цутгалт хийх тохиолдолд даралтад насосны толгойг тохируулж, зуурмагын урсгалыг таслахгүйгээр цутгах хэрэгтэй. минутын дараа бэлдсэн хэв хашмал руу агаар үүсгэхгүйгээр аядуухан хийж өгнө. Хэвтээ болон босоо түвшиний аль алинд ч Sika Grout зуурмагийг дээд түвшинг тултал дүүргэж өгөх хэрэгтэй. Цутгалтын өмнө хэв хашмалыг сайтар бэлдэж, урсахаас хамгаалан чигжсэн байх шаардлагатай. Зуурмаган дахь агаарын бөмбөлөгийг арилгаж зуурмагыг нягтруулахын тулд өнгөлгөөний нийвий ашиглан сайтар нягтруулан дагдаршуулах хэрэгтэй.</p>
Цэвэрлэгээ	<p>Ажил дууссаны дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ хатахаас нь өмнө халуун бүлээн усаар цэвэрлэнэ. Хатаж бэхэжсэн бүтээгдэхүүнийг зөвхөн механик аргаар л цэвэрлэх боломжтой.</p>

## Анхаарах зүйлс

- Хамгийн бага завсар зайн хэмжээ 10 мм, хамгийн ихдээ 50 мм
- SikaGrout® -212 HP бүхий зуурмагыг бэхжилтийн явцад бетоны адил температур болон цаг уурын өөрчлөлтөөс хамгаалах шаардлагатай.
- Ил задгай байгаа цутгалтын зуурмагыг бэхжүүлэхдээ дэвсгэр ус болон Antisol төрлийн арчилгааны бүтээгдэхүүн түрхэж хамгаалах хэрэгтэй.
- SikaGrout® -212 HP-д цемент болон бусад нэмэлт бүтээгдэхүүн нэмж хэрэглэж болохгүй.
- Зуурмагыг бэхжиж эхэлмэгц хольж, хутгаж болохгүй.

## Хэрэглэх үеийн санамж / Хязгаарлалтууд

- Зүсэлт хийгдээгүй талбайг давхарлах болон засварлах зорилгоор ашиглаж болохгүй
- Дэлгэрэнгүй мэдээллийг Цементэн суурьтай гроутын Зааварчилгааны хуудаснаас үзнэ үү.
- ASTM C 1107 стандартын дагуу агшдаггүй.
- Нарны шууд тусгал болон хүчтэй салхи бүхий задгай талбайд хэрэглэхээс зайлхий.
- Заагдсан хэмжээнээс илүү хэмжээний ус нэмж болохгүй.
- Бат бэх гадаргуу дээр цутгах шаардлагатай

## Гүйцэтгэл

Усны хэмжээ (%)	Тогтмол чанар (J тархалт)	Ялгаралт	Шахалтын бат бэх (кг/см <sup>2</sup> )			
			10 цаг	24 цаг	7 хоног	28 хоног
13.5	~ 22 секунд	0	300	550	750	850
14	~ 20 секунд	0	200	500	700	780


Энгийн хэрэглээнд зориулсан бяцхан зөвлөгөө

## Машин тоног төхөөрөмжийн суурь дэрийг гроутлах



Гадаргууг сайтар чийглэж өг, боолтны нүхэнд тогтсон ус үлдээж болохгүй. Боломжтой бол эхлээд анкоровн боолтуудаа гроут бүхий зуурмагаар дүүргээд, дараа нь дэр бүхий зуурмагаа цутгалтыг хий. Зуурмагыг нэгэн жигд урсгаж өгөх хэрэгтэй. Анкоровн боолтоос гадаргуу хүртэлх зай нь хамгийн багадаа 3 х зуурмагын дүүргэгчийн хамгийн том диаметр (ойролцоогоор 10мм) байна.

## Суурьний хавтанд Гроутлах



Ойролцоогоор 24 цаг урьдчилан чийглэж өг. Зуурмагын тогтмол урсалтыг хангах зорилгоор цутгалтыг тогмол даралттайгаар хий. Бүх нүх сүвийг битүүлэн дүүргэх зорилгоор гинж болон төмөр утас ашигла. Зуурмагт агуулагдах агаарын бөмбөлөгүүд хөөн гарах боломжтой байх шаардлагатай.

### Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдэхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

### Sika (Thailand) Limited

Head Office  
700/37 Moo 5, Bangpakong Industrial Park II,  
Bangna-Trad KM.57, Tambol Klong Tamhru,  
Muang District, Cholburi, Thailand 20000

Tel: +66 3821 4270-85  
Fax: +66 3821 4286  
E-mail: sikathai@th.sika.com  
www.sika.co.th

